



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/СЗС

Арвайхээр

**Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын
комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.з, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн “Аж ахуй нэгжийн ээлжит тооллогын улсын комисс томилох” тухай 315 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах аймгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Орлогч дарга: О.Түмэнжаргал (Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга)

Гишүүд: Ц.Идэрсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ч.Гүнсэнхорол (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

С.Цэдэнбалжир (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Н.Эрдэнэсүвд (Аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Цэдмаа (Аймгийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)

Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Ц.Должинсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Аймгийн комиссоос өгсөн нэгдсэн удирдамж, заавар, чиглэлийн дагуу тооллогыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, тоологч нарын халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангаж ажиллах, аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын ажилд хяналт тавин, дүн мэдээг нэгтгэж, тооллогын үйл ажиллагааг явуулсан тайлан, илтгэх хуудсыг бэлтгэн, аймгийн комисст 2021 оны 12 дугаар сарын 06-ны дотор хүлээлгэн өгөхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аж ахуйн нэгж байгууллагын тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймгийн түвшинд хангаж, тооллогыг тогтоосон хугацаанд заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээлэхийг комиссын дарга (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



(Signature)

А.ИШДОРЖ

011101106